



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2029 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг өөрчлөн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай.

- 1) Захиргаа, удирдлагын хэлтэс;
- 2) Дотоод аудит, хяналт, шинжилгээний хэлтэс;
- 3) Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс;
- 4) Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс (Бүтээгдэхүүн баталгаажуулалтын алба, Мэдээлэл технологийн алба, Газар хөдлөл, техник магадлалын албатай);
- 5) Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс;
- 6) Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори
- 7) Нийтийн аж ахуйн хэлтэс;
- 8) Норм, нормативын хэлтэс;
- 9) Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын хэлтэс;
- 10) Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтэс
- 11) Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс;
- 12) Зураг төслийн хяналтын хэлтэс
- 13) Сэлбэ сэргэлт төслийн нэгж
- 14) Нуурс баяжуулах үйлдвэрийн барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх төслийн нэгж

2.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

3.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг үндсэн 240 (хоёр зуун дөч), гэрээт ажилтны тоог 10 (арав), нийт 250 (хоёр зуун тавь) байхаар тогтоосугай.

4.Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг баталж, цалингийн эх үүсвэрийг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаад даалгасугай..

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны ““Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит

132001362
14-r huraldaan.docx

үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг өөрчлөн батлах тухай" 173 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


Ц.БАЯР-ЭРДЭНЭ





Төрийн өмчийн болдлог зохицуулалтын газрын
2024 оны 105 дугаар сарын 1% чи өдрийн
дугаар тогтолцын дүнээр хавсралт

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДЭЭРИЙН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗҮҮЦЛИЙН СХЕМ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2024 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн

..... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Д/д	Албан тушаал	Орон тоо
Нэг. Удирдлага		
1	Захирал	1
2	Ерөнхий инженер	1
3	Хот байгуулалт, зураг төслийн институтын эрхлэгч	1
	Нийт	3
Хоёр. Захиргаа, удирдлагын хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2
4	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн	1
5	Гадаад, дотоод хамтын ажиллагааны мэргэжилтэн	1
6	Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	1
7	Худалдан авалт, гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	1
8	Архивын эрхлэгч	1
9	Бичиг хэргийн ажилтан	2
10	Аж ахуйн үйлчилгээ хариуцсан менежер	1
11	Эмч	1
12	Захирлын туслах	1
	Нийт	14
Дотоод аудит, хяналт, шинжилгээний хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Дотоод аудит хариуцсан мэргэжилтэн	1
3	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	1
4	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	3
	Нийт	6
Гурав. Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс		
1	Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	1
2	Ахлах нягтлан бодогч	1
3	Эдийн засагч	1
4	Нягтлан бодогч	5
5	Хангамжийн нярав	3
6	Борлуулалт, орлогын нярав	1
	Нийт	12
Дөрөв. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс		
(Газар хөдлөл, техник магадлалын алба, Мэдээллийн технологийн алба болон Бүтээгдэхүүн баталгаажуулалтын албатай)		
1	Хэлтсийн дарга	1
2	Ахлах мэргэжилтэн /Бүтээгдэхүүний чанарын менежер/	1
3	Бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт, тохирлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1
4	Барилгын материалын үйлдвэрлэлийн судалгаа, бүтээгдэхүүний баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн	1
5	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн заавар хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	5
Мэдээллийн технологийн алба		

1	Албаны дарга	1
2	Барилгын салбарын нэгдсэн бүртгэл мэдээллийн систем хариуцсан мэргэжилтэн	1
3	Барилгын салбарын технологи, программ хангамжийн хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	1
4	Тоног төхөөрөмж, дотоод сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	4
Газар хөдлөл, техник магадлалын алба		
1	Барилгын чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1
2	Газар хөдлөл, техникийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	2
Тав. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Ахлах инженер /Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, арга хэмжээ хариуцсан/	1
3	Бүс хариуцсан ахлах инженер	3
4	Захиалагчийн техник хяналтын гэрээ, тайлан хариуцсан мэргэжилтэн	1
5	Хяналтын инженер	25
	Нийт	31
Зургаа. Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори		
1	Лабораторийн дарга	1
2	Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн ахлах шинжээч	1
3	Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн шинжээч	4
4	Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн лаборант	4
5	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, тоног төхөөрөмж хариуцсан инженер	1
	Нийт	11
Долоо. Нийтийн аж ахуйн хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Салбарын менежмент, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	2
4	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	2
5	Дулаан хангамж, халаалт, агаар сэлгэлт хариуцсан мэргэжилтэн	1
6	Мэдээллийн сан, орон сууцны асуудалд хариуцсан мэргэжилтэн	1
7	Нийтийн аж ахуйн салбарын хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	9
Найм. Норм, нормативын хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Барилга байгууламжийн архитектур, хийц бүтээцийн төлөвлөлт, угсралт, төсөв үнэ бүрдлийн норм, нормативын баримт бичиг хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Ус, дулааны инженерийн хангамжийн норм, нормативын баримт бичиг хариуцсан мэргэжилтэн	1
4	Барилгын хийц, бүтээц, төлөвлөлтийн норм, нормативын баримт бичиг хариуцсан мэргэжилтэн	1
5	Барилгын механикуулалт, цахилгаан, холбоо дохиопол, автоматжуулалтын норм, нормативын баримт бичиг хариуцсан мэргэжилтэн	1
6	Хот байгуулалт, барилгын төлөвлөлтийн норм, нормативын баримт бичиг хариуцсан мэргэжилтэн	1
7	Барилга байгууламжийн эзлэхүүн төлөвлөлтийн норм, нормативын баримт бичиг хариуцсан	1
8	Барилга угсралт, зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын норм, нормативын баримт бичиг хариуцсан	1

9	Барилгын төсөв үнэ бүрдэл, хөдөлмөр зарцуулалтын норм нормативын баримт бичиг	1
10	Барилгын төсөв, машин механизм, тоног төхөөрөмжийн норм, үнэлгээний норм, нормативын баримт бичиг хариуцсан мэргэжилтэн	1
11	Барилгын эдийн засаг, төсөв үнэ бүрдэл үнэлгээний норм, нормативын баримт бичиг хариуцсан	1
12	Барилга байгууламжийн төсөв үнэ бүрдлийн арга аргачлалын норм нормативын баримт бичгийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
13	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн	2
14	Номын санч	1
	Нийт	15

Ес. Барилга байгууламжийн зураг төсөл, магадлалын хэлтэс

1	Хэлтсийн дарга	1
2	Барилгын бүтээцийн зураг төслийн магадлал хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Барилгын төсөв, үнэ бүрдэл хариуцсан ахлах мэргэжилтэн	1
4	Барилгын бүтээцийн зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
5	Ерөнхий төлөвлөгөө, барилгын төлөвлөлтийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
6	Дулаан хангамжийн зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
7	Цахилгаан хангамжийн зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
8	Барилгын төсөв, үнэ бүрдэл хариуцсан мэргэжилтэн	1
9	Ус хангамж, ариутгах татуургын зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
10	Инженер геологийн судалгааны магадлал хариуцсан мэргэжилтэн	1
11	Нефть, нефтьийн бүтээгдэхүүн, хийн хангамжийн зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
12	Холбоо, дохиоллын зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
13	Усны барилга байгууламжийн зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн	1
14	Зураг төслийн магадлалын судалгаа, мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	14

Арав. Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтэс

1	Хэлтсийн дарга	1
2	Газар зүй, бүс нутаг судлаач	2
3	Хот төлөвлөлтийн архитектор	3
4	Хот төлөвлөлтийн эдийн засагч	2
5	Экологи, хүрээлэн буй орчны судалгаа төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	1
6	Шугам сүлжээ, дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
7	Авто зам, тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8	Инженер геологич	1
9	Газар зохион байгуулагч	2
	Нийт	14

Арван нэг. Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс

1	Хэлтсийн дарга	1
2	Ахлах мэргэжилтэн	1
3	Салбарын инженер, техникийн ажилтны сургалтын зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	2
4	Сургалтын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
5	Салбарын судалгаа, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн	2
6	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1
	Нийт	8

Арван хоёр. Зураг төслийн хяналтын хэлтэс

1	Хэлтсийн дарга	1
2	Ахлах инженер	1
3	Зураг төслийн хяналтын инженер	5

	Нийт	7
Арван гурав. Сэлбэ сэргэлт төслийн нэгж		
1	Төслийн нэгжийн дарга	1
2	Ахлах мэргэжилтэн /Хот төлөвлөлтийн архитектор/	1
3	Авто зам, төлөвлөлтийн инженер	1
4	Геологи, геодези, хайгуулын судалгаа хариуцсан инженер	1
5	Усны барилга, байгууламжийн инженер	1
6	Цахилгааны инженер	1
7	Дулаан хангамжийн инженер	1
8	Холбоо дохиоллын инженер	1
9	Ус хангамж, ариуттых татуургын инженер	1
10	Төсөвчин	1
11	Бичиг хэрэг	1
	Нийт	11
Арван дөрөв. Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх төслийн нэгж		
1	Төслийн нэгжийн зохицуулагч	1
2	Төлөвлөлтийн инженер	2
3	Гэрээ, төсвийн мэргэжилтэн	2
4	Хяналтын инженер	31
5	Орчуулагч	2
6	Баримт бичиг хариуцсан ажилтан	2
	Нийт	40
Арван тав. Аж ахуй үйлчилгээний ажилтнууд		
1	Жолооч	15
2	Үйлчлэгч	11
3	Жижүүр	8
	Нийт	34
Удирдах болон гүйцэтгэх ажилтнууд		
Гэрээгээр ажил гүйцэтгэх ажилтнууд		
Нийт орон тоо		